

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ САЛБАР
ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ГАДААД ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ЛОВУУИГНЭНГИЙН ДУЛАМСҮРЭНГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд: Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын бүлгүүдийн хөгжил, оролцоог хангах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн салбар дундын гэр бүлд ээлтэй цогц бодлого боловсруулж, хүн амын тогтвортой өсөлт, гэр бүл, хүний хөгжлийг дэмжих стратегийн зорилт 2							
Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох:							
1	Арга хэмжээ 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад хамтран ажиллана. /АХ-2050 - 2.3.3, ЗГҮАХ 2024-2028 - 2.1.1.23/	Хуулийн төсөл /тоо/	-	1	Төрийн захиргааны төв байгууллагууд болон НЗДТГ, холбогдох мэргэжлийн байгууллагуудаас Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах албан хаагчдын мэдээллийг албан бичгээр авч, ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалын хавсралтаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан. Мөн дотоод албан бичгээр яамны газар, хэлтсээс хуулийн төсөлд тусгах саналыг авч	01-06	80
		Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /тоо/	-	20			
		ЗГ-ын хуралдааны тэмдэглэл /тоо/	-	2			

					нэгтгэн хуулийн төсөлд санал тусган ажилласан. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/58 тоот тушаалаар байгуулагдсан “Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах дэд ажлын хэсэг”-т ажиллаж, тус хуулийн төслийг дагалдан гарах Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 03 дугаар сард Нийгмийн халамжийн хэлтэстэй хамтран боловсруулж, нийгмийн халамжийн сангаас олгох хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээний талаар санал тусгасан.		
2	Арга хэмжээ 2.3. Дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулна.	Хуулийн төсөл /тоо/	0	1	ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийг хуралд оролцогчдын саналыг тусган хянан сайжруулж байна. Мөн ажлын хэсэг “Монгол дохионы хэл ба хөгжлийн чиг хандлага” хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар 28-ны өдөр Боловсролын	01-06	60
		Үзэл баримтлалын төсөл /тоо/	0	1			

				яам болон харьяа байгууллагууд, СЗСҮТ, МБУЧОС, МУСИҮХ, Сонсголгүйн боловсрол, Тэгш тусгал ТББ-дын төлөөлөл, Олон улсын хөгжлийн болон донор байгууллагын төлөөлөлтэй хамтран зохион байгуулсан. Мөн “Сонсголгүйн боловсрол” ТББ, Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоотой хамтран “Эрт үеийн оролцоо ба сонсголгүйн боловсрол” хэлэлцүүлгийг 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, хуулийн төслийг хэлэлцүүлсэн. Хуулийн төсөл боловсруулах ажлын явц 50 хувьтай байна.	
Дэд арга хэмжээ 2.3.1: Ажлын хэсэг байгуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	10%	ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан.	01-06
Дэд арга хэмжээ 2.3.2: Хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа хийнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	20%	Тайлагнах хугацаа болоогүй.	07-12
Дэд арга хэмжээ 2.3.3: Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулж, батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	5%	Тайлагнах хугацаа болоогүй.	07-12
Дэд арга хэмжээ 2.3.4: Хуулийн төсөл болон түүнийг дагаж гарах хуулийн төслүүдийг боловсруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	25%	Тайлагнах хугацаа болоогүй.	07-12

	Дэд арга хэмжээ 2.3.5: Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	15%	Тайлагнах хугацаа болоогүй.	07-12	
	Дэд арга хэмжээ 2.3.6: Хэлэлцүүлэг зохион байгуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	15%	Тайлагнах хугацаа болоогүй.	07-12	
	Дэд арга хэмжээ 2.3.7: Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагуудаас санал авна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	10%	Тайлагнах хугацаа болоогүй.	07-12	
Зорилт 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах;							
3	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зураглалын төслийг боловсруулна.	Зураглал /тоо/	0	1	Ххөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зураглалыг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулж, тайлант хугацаанд нийт 3 удаа ажлын хэсгийн уулзалтад оролцож, нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгогддог тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээний жагсаалтыг нэгтгэсэн. Үйлчилгээний зураглалын төслийг Эрүүл мэндийн яам, Боловсролын яам холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөлд танилцуулсан. Үйлчилгээний зураглалыг Эрүүл мэнд, Боловсрол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын	01-06	100

					сайдын хамтарсан уулзалтад танилцуулахаар ажиллаж байна.		
4	Арга хэмжээ 4.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг зарим аймаг, дүүрэгт байгуулах санал боловсруулах; /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.26/	Хөгжлийн төвтэй болсон аймаг, дүүрэг /тоо/	6	8	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд тус яамнаас Баянзүрх дүүрэг, Завхан аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, 2026 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Завхан аймагт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 04 дүгээр сард зарлан 7 байгууллага материал ирүүлж, шалгараагүй тул 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр дахин зарласан бөгөөд 06 дугаар сарын 12-ны өдөр нээж, шаардлага хангасан “Морин сувд” ХХК-ын мэдээллийг АХБ-нд 06 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлсэн. Баянзүрх дүүрэгт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын зураг төсөвт магадлал хийлгэхээр Барилгын хөгжлийн төвд хянуулахаар хүргүүлсэн. Мөн тус төвийг барих барилгын ажлын төлөвлөгөөг боловсруулж, АХБ-нд хүргүүлсэн.	01-06	100

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТОД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

Зорилт 1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар дундын уялдаа холбоо, бодлого зохицуулалтыг хангаж, хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах

5	Арга хэмжээ 1.1. Хариуцсан асуудлын чиглэлээр хуулийн төсөл, УИХ, ЗГ-ын тогтоолын төсөлд санал өгөх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, хууль, тогтоол шийдвэрийн төсөлд салбарын бодлогыг тусгасан санал боловсруулж, танилцуулах;	Хэрэгжилтийн хувь	100	100	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/58 тоот тушаалаар байгуулагдсан “Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах дэд ажлын хэсэг”-т ажиллаж, нийгмийн халамжийн сангаас олгох хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээний талаар хуулийн төсөлд санал тусгасан. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас ирүүлсэн Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг тусгах чиглэлээр санал боловсруулж, хүргүүлсэн. УИХ-ын даргын 2024 оны 89 дүгээр захирамжаар байгуулагдсан "Ялгаварлан гадуурхалтын эсрэг авах арга хэмжээний талаар судалгаа хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх бүрэлдэхүүнд ажиллаж байна.	01-06	100
---	--	-------------------	-----	-----	---	-------	-----

Зорилт 2. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, олон улсын байгууллага, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах”

6	Арга хэмжээ 2.1. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөвлөгөөний Хэрэгжилтийн хувь	100	50	Төслийн удирдах хорооны хурлаар 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 28 арга хэмжээтэйгээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, 12,6 тэрбум төгрөгийн төсвийг баталсан бөгөөд Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн дээд хязгаараар 2,9 тэрбум батлагдаж, төсвийн зарцуулалт 1,2 тэрбум буюу 40,3 хувийн гүйцэтгэлтэй байна. Төслийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 28 арга хэмжээнээс хэрэгжих шатандаа байгаа 15 арга хэмжээ, хэрэгжилт удаашралтай 2 арга хэмжээ, Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн дээд хязгаарын саналын дагуу 6 арга хэмжээг хойшлуулсан. Тайлант хугацаанд 6 үнэлгээний хороог ТНБД-ын тушаалаар байгуулж үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан бөгөөд төслийн нэгжтэй хамтран төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад нийт 33 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, ажилласан. Мөн тайлант хугацаанд Азийн хөгжлийн банк болон ТХН-ийн хамтарсан уулзалтыг ГБХНХЯаман дээр 2 удаа зохион байгуулж, төслийн үр дүнг хэлэлцэж, харилцан	01-06	100
---	---	--	-----	----	--	-------	-----

				ойлголцлолын санамж бичгийг байгуулсан.		
Дэд арга хэмжээ 2.1.1. Төслийн нэгжээс зохион байгуулах худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо байгуулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	50	100	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар дараах Үнэлгээний хороог байгуулж, бүрэлдэхүүнд ажилласан. Үүнд: 1. G13 дугаартай Эрт илрүүлгийн аргачлал болон хүүхдийн ягаан дэвтэр хэвлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/42 тоот тушаалаар батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн хязгаарын саналын дагуу ягаан дэвтэр хэвлэх арга хэмжээг түр хойшлуулсан. 2. Төслийн нэгжийн Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан мэргэжилтнийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/43 тоот тушаалаар байгуулж, мэргэжилтнийг сонгон шалгаруулсан. 3. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн W6 дугаартай Завхан аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон	01-06	100

				шалгаруулах үнэлгээний хороог 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/58 тоот тушаалаар байгуулж, тендерийг 04 дүгээр сард зарлаж, тендерт материал ирүүлсэн 7 байгууллагын үнэлгээг хийж, АХБ-нд хүргүүлсэн. Тендерт оролцогч байгууллагуудаас шаардлага хангасан материал ирүүлээгүй тул тендерийг дахин зарлаж, 06 дугаар сарын 12-ны өдөр нээж, үнэлгээг хийхээр ажиллаж байна. 4. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан мэргэжилтэнийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/73 тоот тушаалаар мэргэжилтнийг сонгон шалгаруулсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжид Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан 2 мэргэжилтэн ажиллахаас Сангийн яамнаас ирүүлсэн саналын дагуу 1 мэргэжилтнийг сонгон шалгаруулж, ажиллуулж байна. Мөн тайлант хугацаанд G19 дугаартай Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд туслах технологи, тоног төхөөрөмж нийлүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны тушаалын төсөл, W7 дугаартай Баянзүрх дүүрэгт		
--	--	--	--	--	--	--

				баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны тушаалын төслийг боловсруулж, удирдлагуудад хянуулж байна.		
Дэд арга хэмжээ 2.1.2. Төслийн нэгжээс холбогдох төрийн байгууллага, хамтран ажиллагч талуудад дэмжлэг үзүүлэх;	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	50	100	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад нийт 33 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, ажилласан байна. Үүнд: 1. Сангийн яам руу ТХН-ийн 2025 оын төсөв, санхүүжилт, төслийн зардлын ангилал шилжүүлэх, холбогдох журмын дагуу зөвшилцөх 7 албан бичиг; 2. Барилгын хөгжлийн төв рүү зураг төсөвт магадлал хийлгэх тухай 2 албан бичиг; 3. Нийслэлийг Засаг даргын Тамгын газарт Баянзүрх дүүрэгт баригдах төвийн газрын асуудлаар 1 албан бичиг; 4. Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газарт Баянзүрх дүүрэгт баригдах төвийн газрын асуудлаар 1 албан бичиг; 5. Архангай аймгийн Засаг даргын Тамгын газарт 1 албан бичиг; 6. Азийн хөгжлийн банканд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах,	01-06	100

				гүйцэтгэгч сонгон шалгаруулахтай холбоотой 2 албан бичиг; 7. Тендерт материал ирүүлсэн байгууллагуудад мэдэгдэл хүргүүлэх тухай 19 албан бичиг. Мөн төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны Портеж хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх, ажлын байранд дадлагажуулах сургалт болон Харааны бэрхшээлтэй иргэдтэй харилцах арга зүйн сургалт"-ын удирдамж, төсвийг ТНБД-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/183 тоот тушаалаар удирдамж, төсвийг батлуулсан. Сургалтыг 06 дугаар сарын 15-30-ны өдрийн хооронд зохион байгуулахаар удирдамжид тусгаж, Сангийн яам руу санхүүжилтийн хүсэлтийг хүргүүлсэн. Тайлант хугацаанд Азийн хөгжлийн банк болон ТХН-ийн хамтарсан уулзалтыг ГБХНХЯаман дээр 2 удаа зохион байгуулж, төслийн үр дүнг хэлэлцэж, харилцан ойлголцлолын санамж бичгийг байгуулсан. Төслийн удирдах хорооны хурлыг 06 дугаар сард хийхээр төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна.		
--	--	--	--	---	--	--

7	Арга хэмжээ 2.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;	Хэрэгжилтийн хувь	100	50	“Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, хамгааллын чиглэлээр туссан зорилтыг хэрэгжүүлэхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт зарцуулах 2025 оны төсөв”-ийг ГБХНХСайдын 2025 оны А/82 тоот тушаалын хавсралтаар батлуулсан. Уг төсвийн хуваарьт “Сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэл хүргэхэд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний хүрээнд 60 сая төгрөг тусгагдсаж, “Дохионы хэлмэрчдийн холбоотой хамтран 6 дохионы хэлмэрчтэй хөлсөөр ажиллах гэрээг байгуулж, ТНБД-аар батлуулсан. Боловсролын яам болон харьяа байгууллагууд, СЗСҮТ, МБУЧОС, МУСИҮХ, Сонсголгүйн боловсрол, Тэгш тусгал ТББ-дын төлөөлөл, Олон улсын хөгжлийн болон донор байгууллагын төлөөлөлтэй хамтран “Монгол дохионы хэл ба хөгжлийн чиг хандлага” хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар 28-ны өдөр зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн дэх ТББ-ын төлөөлөлтэй тогтмол уулзалтыг	01-06	100
---	--	-------------------	-----	----	--	-------	-----

				зохион байгуулж, 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 19 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна. ГБХНХЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх ТББ-ыг тодорхой тусгаж өгсөн. Дэд зөвлөлөөс дэх төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо” ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгууллагуудын Шүхэр бодлогын нэгдсэн зөвлөлтэй хамтран “Нэг асуудал, нэг шийдэл” хэлэлцүүлгийг 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлаар санал тусгахаар төрийн болон ТББ-ын 30 гаруй төлөөлөл оролцсон.		
Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх үндэсний зөвлөл болон дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааны зохицуулалтыг хариуцах” зорилтын хүрээнд						
8	Арга хэмжээ 3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах, тайланг хянах;	Төлөвлөгөөний Хэрэгжилтийн хувь	67,1	50	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн хурлыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хамтран зохион байгуулж, тус хурлаар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 6 яамны дэд зөвлөлийн үйл ажиллагаанд	01-06 100

					хийсэн сонсголоос гарсан дүгнэлт, зөвлөмж, албан даалгавар танилцуулсан бөгөөд мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 19 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна. Мөн зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 6 яамны үйл ажиллагааны тайлангийн сонсголыг 12-01 сард хамтран зохион байгуулж, 6 яаманд хүргүүлэх зөвлөмжийг нэгтгэж, удирдлагад танилцуулсан.		
9	Арга хэмжээ 3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, хагас бүтэн жилээр тайлагнах;	Төлөвлөгөөний Хэрэгжилтийн хувь			ГБХНХЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, тус хурлаар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Дэд зөвлөлөөс 2025 онд эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд 9 арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулах хүрээнд 6 арга хэмжээ, нийт 15 арга хэмжээг харьяа агентлаг болон төрийн бус байгууллагатай хамтран	01-06	80

					хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн шатандаа байгаа 13 арга хэмжээ байна. Засгийн газрын 2023 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хангах зөвлөлийн ажиллах журам”-д заасны дагуу хагас жилийн тайланг 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ажлын албанд хүргүүлэхээр хэрэгжилтийг нэгтгэж байна.		
Зорилт 5. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд							
10	Арга хэмжээ 3.1. Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, ажиллах;	Хэрэгжилтийн хувь	100	100	“Авлигын эсрэг хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.3. “Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй” гэж заасны дагуу 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлсэн.	01-06	100
11	Арга хэмжээ 3.2. Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах	Бодлогын үндэслэлтэй санал өгсөн байна.	100	100	Газрын тайлангийн батлагдсан хуваарийн дагуу дараах тайланг нэгтгэж, хугацаанд нь хүргүүлсэн. Үүнд: 1. “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт /томоохон арга	01-06	100

				хэмжээний дэлгэрэнгүй танилцуулга/ 2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сар бүрийн хэрэгжилт болон 2021 оноос хойших Засгийн газрын тогтоол, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтээр 30 хувьтай үнэлэгдсэн арга хэмжээний биелэлт, Засгийн газрын тогтоол, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтээр 70 ба түүнээс дээш үнэлэгдсэн арга хэмжээний биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын байдлаар /; 3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тус хэлтсийн хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт; 4. Газрын 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тус хэлтсийн хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт; 5. Хэлтсийн 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт; 6. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилт; 7. ГБХНХЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт;		
--	--	--	--	---	--	--

				8. Газрын албан хаагчдын 05 дугаар сарын 7 хоногийн төлөвлөгөө, хэрэгжилт; 9. Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 41 дүгээр хуралдааны тэмдэглэл 10. Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар хуралдааны тэмдэглэл 11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд 2026-2028 онд шаардагдах дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн танилцуулга, төсвийн төслийг нэгтгэж, боловсруулсан. Мөн албан тушаалын чиг үүрэгт хамаарах хариуцсан асуудлаар дараах тайлангийн хэрэгжилтийг хагас жилийн байдлаар гаргасан. Үүнд: 1. Монгол Улсын нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны үндэсний 5 дугаар төлөвлөгөөний 2025 оны хагас жилийн тайлан; 2. Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилт; 3. Улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн 2025 оны хагас жилийн хэрэгжилт;		
--	--	--	--	---	--	--

12	Арга хэмжээ 3.3. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;	Шийдвэрлэлтийн хувь	100	100	Албан хэрэг хөтлөлтийн erp.mlsp.gov.mn цахим системээр ирүүлсэн хариутай 15, хариугүй 41, нийт 56 албан бичиг, иргэнээс ирүүлсэн 12 өргөдлийг хүлээн авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, хариуг хүргүүлж ажилласан. Мөн албан тушаалын чиг үүргийн хүрээнд 54 албан бичгийг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна.	01-06	100
13	Арга хэмжээ 3.5. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлага, хэрэгжилтийг хангаж, баримт бичгийг хөтлөн явуулах, архивын нэгж үүсгэх;	Баримт бичгийг стандартын дагуу боловсруулан хөтөлж, архивт хүлээлгэн өгсөн байна.	100	100	“Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 351 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам”-ын 5.1-д заасны дагуу хуралдаанаар оруулах асуудалд тавигдах шаардлагын дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж, Засгийн газрын хуралдаанаар 2025 онд дараах 2 асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын тогтоолыг батлуулсан. Үүнд: 1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 164 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 212 дугаар тогтоолоор “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолыг батлуулсан.	01-06	100

				"Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2025 оны 212 дугаар тогтоолд нийцүүлэн Орон нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дүрэм, бүтэц, орон тоо батлах тухай тушаалын төслийг боловсруулж, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/133 тушаалын 1 дүгээр хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн зохион байгуулалтын бүтэц, 2 хавсралтаар төвийн дүрмийг батлуулсан. 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан тушаалын чиг үүргийн хүрээнд хадгаламжийн нэгжийг үүсгэж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.		
--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Баримт бичиг боловсруулах	Хэрэгжилтийн хувь	-	100	1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төрийн захиргааны төв	01-06	100

					байгууллагуудаас саналыг авч нэгтгэн ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд 99 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын 2025 оны 04 сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. 2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээний (Дэмжих төв) аргачлал заавар”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээний үнэ тарифыг төрийн болон төрийн бус байгууллагуудын саналыг нэгтгэн боловсруулж, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/64 тушаалын 4, 5 дугаар хавсралтаар тус тус батлуулсан. 3.ТНБД-ын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/113 дугаар тушаалаар байгуулагдсан “EFAMILY системийн ажлын даалгавар боловсруулах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн сангийн ажлын даалгавар боловсруулах, ХБХЭМБНХК-ын мэдээллийн сангийн нэмэлт сайжруулалт, Дотоод сүлжээг шинэчлэх, сайжруулах үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг зохион байгуулах” үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, ажлын даалгаврыг хамтран боловсруулсан. 4.ТНБД-ын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн санг		
--	--	--	--	--	---	--	--

					хөгжүүлэх үйл ажиллагаа", "Сонсголын бэрхшээлтэй иргэний дуудлагын видео үйлчилгээг сайжруулах үйл ажиллагаа" арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Ажлын хэсэгт ажиллах				1.УИХ-ын гишүүн О.Саранчулууны санаачлан зохион байгуулсан "Нутгийн удирдлагын оролцоо үндэсний зөвлөгөөн-2025" зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан. Тус зөвлөгөөн 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан бөгөөд аймаг, дүүргийн Засаг дарга нар, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнүүд болон ОУБ-ын төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг төрийн бус байгууллагын төлөөлөл 80 гаруй хүн оролцсон. 2.УИХ-ын даргын 2024 оны 89 дүгээр захирамжаар байгуулагдсан "Ялгаварлан гадуурхалтын эсрэг авах арга хэмжээний талаар судалгаа хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх бүрэлдэхүүнд ажиллаж байна. 3.ТНБД-ын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/175 дугаар тушаалаар байгуулагдсан "Засгийн газрын 2024 оны "Ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 357 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан, Монгол Улс дахь	01-06	100

					Хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний дөрөвдүгээр илтгэлийн боловсруулах ажлын хэсэг"-т нарийн бичгийн даргаар ажиллаж, тайланг нэгтгэсэн.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар холбогдох хууль эрх зүй, дүрэм, журмыг судлах, судалгааны баримт материалтай танилцах;	Хэрэгжилтийн хувь	100	100	Бодлогын баримт бичиг төлөвлөх, салбарын холбогдох хууль, журамд санал боловсруулах Ажлын хэсгүүдэд ажиллаж, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. Тайлант хугацаанд хуулийн төсөлд 3, журмын төсөлд 1, дүрмийн төсөл 2, гэрээний төсөлд 1, аргачлалын төсөлд 1, нийт 7 саналыг тус тус боловсруулж, санал тусгасан.	01-06	100
2.	Арга хэмжээ 2. Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр зохих сургалтад хамрагдах, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох;	Хэрэгжилтийн хувь	100	100	Энэтхэг улсын Засгийн газрын тэтгэлгээр Олон улсын Хууль боловсруулах арга зүйн 36 дахь удаагийн сургалтад Нью дели хотод 1 сар хамрагдаж, сертификат авсан. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тул 01 дүгээр сарын 30-ны өдөр шалгалт өгч, худалдан	01-06	100

					авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг хугацаагүйгээр сунгуулсан.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний салбар дундын
зохицуулалт, нийгмийн түншлэл, гадаад төсөл,
хөтөлбөрийн бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч
(Албан тушаал)

.....
(Нэр, гарын үсэг)

/Л.Дуламсүрэн/

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

(Огноо)

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ,
НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ГАДААД ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ЛОВУУИГНЭНГИЙН ДУЛАМСҮРЭНГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН
ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Нэгжийн нэр: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангах, оролцоо, хүртээмжийг сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох:					
1	Арга хэмжээ 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон, дагалдан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад хамтран ажиллана. /АХ-2050-2.3.3, ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.23/	42	10	52	52
2	Арга хэмжээ 2.3. Дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулна.	51	7	58	58
	Дэд арга хэмжээ 2.3.1. Ажлын хэсэг байгуулна.	60	7	67	67
	Дэд арга хэмжээ 2.3.2. Хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа хийнэ.	42	7	49	49
Зорилт 4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил бодлогын удирдамжаар хангах;					
3	Арга хэмжээ 4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний зураглалын төслийг боловсруулна.	42	7	49	49
4	Арга хэмжээ 4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг зарим аймаг, дүүрэгт байгуулах, санал боловсруулах /ЗГҮАХ 2024-2028 -2.1.1.26/	60	10	70	70
АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТОД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:					
Зорилт 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар дундын уялдаа холбоо, бодлого зохицуулалтыг хангаж, хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах					
5	Арга хэмжээ 1.1. Хариуцсан асуудлын чиглэлээр хуулийн төсөл, УИХ, ЗГ-ын тогтоолын төсөлд санал өгөх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, хууль, тогтоол шийдвэрийн төсөлд салбарын бодлогыг тусгасан санал боловсруулж, танилцуулах;	60	10	70	70
Зорилт 2. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, олон улсын байгууллага, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах"					
6	Арга хэмжээ 2.1. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтээр				

	хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах" төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 2.1.1. Төслийн нэгжээс зохион байгуулах худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо байгуулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	60	10	70	70
	Дэд арга хэмжээ 2.1.2. Төслийн нэгжээс холбогдох төрийн байгууллага, хамтран ажиллагч талуудад дэмжлэг үзүүлэх;	60	10	70	70
7	Арга хэмжээ 2.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;	60	7	67	67
Зорилт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх үндэсний зөвлөл болон дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааны зохицуулалтыг хариуцах" зорилтын хүрээнд					
8	Арга хэмжээ 3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах, тайланг хянах;	42	7	49	49
9	Арга хэмжээ 3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, хагас бүтэн жилээр тайлагнах;	42	7	49	49
Зорилт 5. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
10	Арга хэмжээ 5.1. Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, ажиллах;	60	10	70	70
11	Арга хэмжээ 5.2. Хариуцсан асуудлын чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах	60	10	70	70
12	Арга хэмжээ 5.3. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;	60	10	70	70
13	Арга хэмжээ 5.4. Тайлан мэдээний батлагдсан хуваарийн дагуу хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг болон өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, бусад мэдээ, судалгааг нэгтгэн тайлагнах;	60	10	70	70
14	Арга хэмжээ 5.5. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлага, хэрэгжилтийг хангаж, баримт бичгийг хөтлөн явуулах, архивын нэгж үүсгэх;	60	10	70	70
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Баримт бичиг боловсруулах	60	10	70	70
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Ажлын хэсэгт ажиллах	60	10	70	70
Дундаж оноо:					

Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар холбогдох хууль эрх зүй, дүрэм, журмыг судлах, судалгааны баримт материалтай танилцах;	100	15	15
2.	Арга хэмжээ 2. Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр зохих сургалтад хамрагдах, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох;	100	15	15
Дундаж оноо			15	15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	6	6
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
Дундаж оноо		6,6	6,6

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8,0

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	64
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6,6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =		93,6 93,6

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн дарга

 (С.Рэгзэн)

(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний салбар дундын зохицуулалт, нийгмийн түншлэл, гадаад төсөл, хөтөлбөрийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч

Төрийн жинхэнэ албан хаагч:

..... (Л.Дуламсүрэн)

2025.06.13.....

(огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....

(В.Түвшинжаргал)

2025.06.20.....

(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Яамны хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч

.....

(Б.Баянжаргал)

2025.06.20.....

(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны

Төрийн нарийн бичгийн дарга



..... (Л.Мөнхзул)